

БУЯНТ ГОЛЫН АЙ САВЫН ХӨРСӨН БҮРХЭВЧ, ХӨРСНИЙ ШИНЖ ЧАНАР

О.Батхишиг, Н.Нямсамбуу, Г.Бямбаа, Ц.Болормаа, Д.Ихбаяр
Газарзүйн хүрээлэн, ШУА
Email: batkhishig@gmail.com

Буянт голын ай сав нь Монгол орны баруун хэсгийн чухал газар нутаг болох бөгөөд баруун бүсийн хамгийн том хот болох Ховд хот энд байрлана. Монгол улсын засгийн газраас Буянт голын адаг орчимд 2400 га услалтын систем барихаар төлөвлөж байна. Хөрсөн бүрхэвч ба хөрсний шинж чанар нь гадаргын болон газрын усны шинж чанар горимд нөлөөлдөг. Ялангуяа хөрсний ус физик шинж чанар нь гадаргын урсац, нэвчилт, улмаар голын урсацыг тодорхойлох гол хүчин зүйлийн нэг болно. хөрсөн бүрхэвч нь байгалийн чухал нөөцийн нэг болох бөгөөд тухайн бүс нутгийн эдийн засаг хөдөө аж ахуйн хөгжилтэй шууд холбоотой гэж хэлж болно. Энэхүү судалгааны ажил нь Буянт голын ай савын голлох хөрсний морфологи, хими, ус-физик шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, сав газрын 1 : 500 000 масштабын хөрсний зураг зохиох зорилготой.

Судалгаа явуулсан газар нь Монгол орны баруун хэсэгт Ховд, Баян-Өлгий аймгийн газар нутагт оршдог. Физик-газарзүйн мужлалаар Монгол Алтайн уулархаг нутаг болох бөгөөд баруун хэсэгтээ өндөр уулстай далайн түвшингөөс дээш 3000-4000 метр хүртэл өндөр мөнх цас мөсөн голтой, (хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 4013.9м өндөр Тахилт оргил, Хөх Сэрхийн нуруу) хамгийн нам дор газар нь Хар ус нуур далайн түвшнөөс дээш 1157.3 м өндөр. Ихэнхдээ уулархаг налуу гадарга зонхилох бөгөөд, уулс хоорондын хөндий, хавцал ихтэй, зөвхөн голын доод хэсгээр тэгшивтэр гадаргатай. Өндөр уулсаар хад асгатай, ар хажуугийн дээд хэсгээр өндөр уулын нугатай, уулын хажуу нь үндсэндээ хуурай хээр, доод тэгшивтэр газар нь хуурай, цөлийн-хээрийн ландшафттай.


Судлагдсан байдал

Буянт голын сав газрын хөрсний мэдээ материал хомс байдаг. Ихэвчлэн голын савын доод хэсэгт хөрсний судалгаа хийсэн байдаг бөгөөд голын эхэн хэсэг Дэлүүн сум орчмын газар цөөн тооны хөрсний зүсэлт, мэдээлэлтэй. Оросын хөрс судлаач Андреев нь Буянт голын адаг орчмыг 1930 онд судалсан анхны хөрс судлаач юм. Тэрээр Буянт голын сав газрын доод хэсгийн тариалангийн хөрсийг голчлон судалж байсан байна. 1936 онд “*Буянт голын адаг дахь газрын хөрс ба Ховд аймгийн аж ахуйн байдал*” гэдэг жижиг ном хэвлүүлсэн байна. Мөн 1975 онд хөрс судлаач Т.Мөнхбат, Ч.Сүрэн нар Улсын газар зохион байгуулах Институтын шугамаар Ховд аймгийн хөрсний судалгаа хийж 1977 онд “*Ховд аймгийн хөрсний судалгааны тайлан*” бичсэн байна (Мөнхбат & Сүрэн, 1977). 1970 оноос одоог хүртэл Монгол Оросын зарим нэгэн хөрс судлаачид Ховд аймагт хөрсний судалгаа хийж байсан байна. Энэ судалгааны ажил нь ихэвчлэн Ховдоос Өлгий хот явах замын дагуу болон Хар ус нуурын орчмыг хамааран явагдаж байсан (Ногина 1984, Лхагвасүрэн 2001, Доржготов 2003, Батхишиг 2009). Оросын хөрс судлаач Андреев 1936 онд Буянт голын адаг орчмын 1 : 300 000 масштабтай хөрсний зураг зохиосон байна. Хөрс судлаач Т.Мөнхбат болон Ч.Сүрэн нар 1977 Ховд 1 : 200 000 масштабтай хөрсний зураг зохиосон. Энэ зурагт уулархаг газар нутаг ороогүй ба зөвхөн тэгш талархаг газар, Буянт голын доод хэсэг, уулс хоорондын хөндийн хэсгийн хөрс хамрагдсан (Мөнхбат & Сүрэн, 1977). 1981 онд Орос, Монголын хөрс судлаачид агаар сансрын зураг ашиглаж Монгол орны 1 : 1 000 000 масштабтай хөрсний зураг зохиосон нь харьцангуй нарийвчлал сайн зураг болсон бөгөөд уулархаг газар, ой мод зэрэг бүх газар нутгийг хамарсан байдаг.

Арга зүй

Хөрсний хээрийн судалгааг 2012 оны 6-р сард явууллаа. Нийт 40 ш. хөрсний зүсэлт хийж 159 ш. хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд зориулан авлаа. Дээжийг хөрсний үе давхарга бүрээс авсан. ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид хөрсний хими-физик шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Хөрсийг агаарын хуурай нөхцөлд хатааж 2 мм-ээр шигшиж задлан шинжилгээ хийсэн. Лабораторийн задлан шинжилгээгээр рН, CaCO_3 , Цахилгаан дамжуулах чанар, ялзмаг, хөдөлгөөнт фосфор, кали, нитрат мөн хөрсний ус-физик шинж чанарын үзүүлэлтүүд чулуу (>10 мм, 10-5мм, 5-2мм), механик бүрэлдэхүүн (элс 2-0.05 мм, тоос 0.05-0.002 мм, шавар < 0.002 мм), эзлэхүүн жин, анхдагч нэвчилт, хээрийн чийг багтаамж, сүвэрхэгшилт, ханасан чийгийн нэвчилт болон ургамал чийг үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Хөрсний ялгаатай үе давхаргуудын үзүүлэлтүүдийг бүх хөрсөнд ижил 0-30, 0-50, 0-100 см зузаан хөрсөнд тооцоолсон. Хөрсний зузаантай харьцангуй жигнэсэн дундаж үзүүлэлтүүдийг бодсон. Сав газар тус бүрийн хөрсний хими, ус-физик шинж чанарын дундаж үзүүлэлтүүдийг 1 : 500 000 масштабын хөрсний зургийн ялгавар бүрийн талбайг тооцож жигнэсэн дундаж үзүүлэлтүүдийг тооцоолж бодлоо.

Буянт голын сав газрын хөрснийг шинэчлэн зохиолоо. Зургийг шинэчлэн зурахад дараах материалуудыг ашиглалаа: 2012 оны хөрсний хээрийн судалгааны материал, Топо зураг 1 : 500 000М, 1 : 100 000М, 1 : 1 000 000М Хөрсний зураг (1981), 1 : 200 000М Ховд аймгийн хөрсний зураг (1977), Сансрын зураг: i-cubed 15m eSAT imagery, Landsat 30 meter, 3 arc second DEM SRTM. Буянт голын сав маш их алаг цоог хөрсөн бүрхэвчтэй учраас хөрсний ялгаваруудыг ихэвчлэн бүрдэл хөрсний хэлбэрээр ялгасан.



Зураг 1. Хөрсний дээж авсан цэгүүд

Хөрсөн бүрхэвч

Буянт голын ай сав нь хэрчигдэл ихтэй уулархаг газар нутаг зонхилсноос шалтгаалж хөрсөн бүрхэвч нь маш их алаг цоог. Монгол орны хөрс газарзүйн мужлалтаар хөрсний өндрийн бүсчлэлийн Монгол-Алтайн хэвшинжид хамаарна (Үндэсний атлас, 2009). Буянт голын ай сав газарт байгалийн бүс бүслүүр, газрын гадаргаас хамааран 3 бүлэг хөрсийг ангилж болно:

- Уулын чулуурхаг хөрс
- Уулс хоорондын хөндий болон талархаг газрын хээрийн хөрс
- Чийгт гарлын хөрснүүд, голын татам, эргийн бүсээр

Буянт голын орчмын доод хэсэг, Ховд хотын орчмоор *Говийн бор болон Цайвар хүрэн* хөрс тогтворждог. Голын дээд хэсэг, Дэлүүн хавиар *Хүрэн* хөрс тархана. Уулархаг газраар *Чулуурхаг Хүрэн* хөрс, өндөр уулаар *Уулын нугын болон Уулын хээрийн* хөрстэй. Буянт голын татмаар *Аллювийн нугын хайргархаг, Аллювийн ширэгт хайргархаг* хөрс тогтворжсон байдаг. Жижиг цутгал голын эрэг орчмын газраар *Нугын чулуурхаг* болон *Нугын цэвдэгт* хөрс тархана.

Уулын хамгийн өндөр хэсэгт мөнх цас мөсөн голоос доош өвөр хажуугийн 2700-3000 метр д.т.д. ар хажуугийн 2400-2600 метр хүртэл налуу хажуу газраар өндөр уулын бүлэг хөрс тархана. Газарын гадарга, ургамал бүрхэвчийн байдлаас шалтгаалж *Чулуурхаг нимгэн цэвдэгт* ба *Хүлрэнцэр чулуурхаг цэвдэгт* хөрстэй. Ихэвчлэн сөөг, хөвдтэй хотгордуу газраар *Хүлрэнцэр чулуурхаг цэвдэгт* хөрстэй. Энэ хөрс нь 13-18 % хүртэл өндөр органикийн агууламжтай, урвалын орчин сул хүчиллэг шинж чанартай. Өндөр уулын альпийн нугын ургамалшил доор бараан хар өнгийн органик хуримтлалын давхарга бүхий *Чулуурхаг нугын бараан* хөрс тогтворжино. Өндөр уулын арай хуурай хэсгээр бушилз, ботууль бүхий өндөр уулын толбот хээрийн ургамалтай газраар *Чулуурхаг бүдүүн ялзмагт* болон *Чулуурхаг Нугын* хөрс тогтворждог. Энэ хөрс нь нугын хөрстэй харьцуулбал чийг арай дутмаг, ялмагийн агууламж багатай. Уулын хээр болон нугын завсарын орчинд *Чулуурхаг Нугат-хээрийн* хөрс тархана.

Буянт голын сав газарт гол төлөв уулын хөрс давамгай байдаг бөгөөд энд *Чулуурхаг Хүрэн* хөрс зонхилно. Энэ хөрс нь уулын хажуугийн дунд болон доод хэсэг д.т.д 2700-аас 2400 метр хоорондох өндөрт тогтворждог. Хөрсний зүсэлтийн дунд болон доод хэсгээр кальци кабонатын хуримтлалтай. *Чулуурхаг карбонатлаг хүрэн* хөрс нь кальцийн агууламж илүүтэй. *Чулуурхаг н цайвар хүрэн* хөрс нь д.т.д 2400м болон 2200 метр өндрийн хооронд тогтворждог. *Цайвар Хүрэн* хөрсний ялмагийн агууламж 1-2 % буюу *Хүрэн* хөрснөөс бага байдаг.

Буянт голын сав газрын доод хэсэг, жижиг уулс болон дов толгодоор ялмагийн агууламж багатай *Чулуурхаг Цайвархүрэн* хөрс тогтворждог. Энэ хөрс нь чулуурхаг, гадаргаас эхлэн карбонаттай, органикийн агууламж нь бага 1 % орчим байдаг.

Дэлүүн орчмын уулс хоорондын тэгшивтэр хөнлий газраар *Хүрэн* хөрстэй. Энэ хөрсний хээрийн чийг багтаамж харьцангуй өндөр 18-25 % (эзэлхүүний) хүрнэ. Хүрэн хөрснийн ялмагт давхарга 20-40 см зузаан. Эгц налуу хажуу чулуурхаг газраар *Нимгэн чулуурхаг хүрэн* хөрстэй. Хотгордуу чийглэг газраар *Нугын хүрэн* хөрстэй, хээрийн чийг багтааж 35 % хүтэл өндөр. Буянт голын сав газрын доод хэсгээр, талархаг газраар *Говийн Бор* хөрс тархана. Энэ хөрсний шим тэжээлийн түвшин бага, хөрсний урвалын орчин шүлтлэг 8.0-8.5, гадаргаасаа карбонаттай. Чулуурхаг учраас хээрийн чийг багтаамж багавтар буюу 20 % орчим болно. Буянт голын дээд хэсгийн жижиг цутгал голын эрэг орчмоор ялмагийн агууламж өндөртэй *Нугын* хөрс тогтворждог. Өндөрлөг газрын гадарга, удаан үргэлжлэх хүйтний улирал, хөрсний чийг хангаамж өндөр байдгаас шалтгаалж энэ хөрсний доод хэсэгт 1-2 метрд олон жилийн цэвдэгтэй.


Хүснэгт 1. Хөрсний шинж чанарын үзүүлэлтүүд

Газрын бүрхэвч	Хөрс	SP	Гүн, см	pH _{H2O} (1:2.5)	CaCO ₃ %	Органикийн агууламж %	EC _{2.5} dS/m	Хээрийн чийг багтаамж, % (VWC)
Уулын тундр	Хүлрэнцэр чулуурхаг цэвдэгт	27	0-5	6.95	0.00	18.49	0.300	48.8
			5-25	7.43	0.00	13.39	0.254	41.4
			25-50	7.45	0.00	4.75	0.097	31.5
Уулын нуга, толбот хээр	Чулуурхаг Нугын бараан	22	0-5	7.53	0.00	9.93	0.516	34.5
			5-18	7.91	0.00	5.26	0.090	25.9
			18-30	7.68	0.00	10.39	0.512	35.2
			30-45	8.28	0.00	5.49	0.097	30.4
			45-60	7.75	0.00	2.49	0.108	21.4
	Чулуурхаг Бүдүүн ялзмагт	12	0-8	5.45	0.00	8.61	0.340	32.8
			8-20	6.93	0.00	5.86	0.212	28.5
Уулын хээр	Чулуурхаг Хүрэн	25	0-6	8.25	2.00	1.86	0.079	19.8
			6-10	8.27	1.64	0.36	0.060	17.0
	Чулуурхаг Цайвархүрэн	30	0-13	7.23	0.00	2.45	0.045	25.0
			13-35	8.04	3.27	0.67	0.165	22.8
			35-50	7.89	1.76	0.24	0.089	16.7
Хээр	Сайргархаг Хүрэн	17	0-2	7.68	1.82	1.47	0.204	18.9
			2-18	8.41	2.00	2.94	2.091	25.3
			18-30	8.62	3.82	1.39	1.534	24.6
			30-50	8.14	4.73	0.30	1.105	13.5
Хуурай хээр	Сайргархаг нимгэн Цайвархүрэн	15	0-10	7.65	0.18	1.93	0.083	22.3
			10-25	8.10	11.09	0.97	0.099	22.1
			25-40	8.32	10.72	0.48	0.096	18.0
			40-60	8.36	4.54	0.07	0.074	16.3
	Сайрын хайргархаг	19	0-1	5.67	2.18	1.82	0.249	24.5
			1-12	6.15	8.54	1.72	0.047	22.7
			12-30	7.66	0.97	0.91	0.213	24.7

Буянт голын савын татам болон адаг орчмын газраар Аллювийн элсэнцэр хайргархаг хөрс зонхилон тархдаг. Татмын хөрсөн бүрхэвч нь газрын гадарга, хурдас чулуулгийн байдлаас шалтгаалж ихээхэн алаг цоог.

БУЯНТ ГОЛЫН АЙ САВЫН ХӨРСНИЙ ШИНЖ ЧАНАР

(Дунджаар 0-50 см зузаан хөрсөнд)




Зураг 3. Буянт голын ай савын хөрсний шинж чанар

Хүснэгт 2. Уулс хоорондын хөндий, талархаг газрын хөрсний шинж чанарын үзүүлэлтүүд

Газрын бүрхэвч	Хөрс	SP	Гүн, см	pH _{H2O} (1:2.5)	CaCO ₃ %	Органикийн агууламж %	EC _{2.5} dS/m	Хээрийн чийг багтаамж, % (VWC)	
Хээр, Хуурай хээр, Цөлөрхөг хээр	Элсэнцэр Цайвархүрэн	40	0-10	7.89	0.00	0.43	0.058	17.0	
			10-25	8.45	5.09	0.30	0.069	19.8	
			25-50	8.56	4.86	0.14	0.047	16.4	
	Элсэнцэр Бор	29	0-10	7.62	0.00	0.21	0.046	18.3	
			10-25	7.75	0.00	0.22	0.033	16.2	
			25-50	8.49	0.00	0.36	0.052	14.7	
			50-70	8.59	0.36	0.35	0.053	13.4	
Намаг, Нугархаг- намаг	Нугын глейт	5	0-10	7.52	0.00	4.00	0.150	29.5	
			10-25	7.76	0.00	4.05	0.064	28.9	
			25-40	7.10	0.00	2.92	0.055	29.8	
			40-100	6.70	0.00	2.82	0.152	27.6	
	Нугын бараан цэвдэгт	21	0-10	8.10	0.00	19.54	0.124	48.9	
	Татмын нуга, нугархаг- намаг	Аллювийн элсэнцэр хайрган	1	0-2	8.38	0.00	0.51	0.072	18.4
				2-10	8.53	0.00	0.50	0.050	21.8
10-20				8.31	1.64	0.74	0.168	21.8	
20-40				8.54	4.18	0.23	0.102	17.6	
Аллювийн нугын глейт		23	0-10	8.14	3.09	4.57	0.338	25.5	
			10-20	7.11	0.00	2.91	0.116	25.2	
			20-40	7.82	0.00	1.34	0.047	28.8	
			40-60	8.19	0.00	0.28	0.038	14.3	
Газар тариалан	Антросол хайргархаг элсэнцэр	14	0-8	8.26	0.00	0.52	0.110	17.7	
			8-20	8.70	0.00	0.57	0.054	21.5	
			20-40	8.44	0.00	0.28	0.048	14.1	

Буянт голын адаг орчмын хөрс ихээхэн хайрга чулуутай, хөрсний дээд хэсгийн ялзмагт давхаргын зузаан 20-30 см орчим, түүнээс доош хайрган хурдастай. Иймээс хөрсний хээрийн чийг багтаамж бага, нэвчилт харьцангуй өндөр байдаг. Зөвхөн Аллювийн намгийн ба Аллювийн нугат-намгийн хөрс нь хөрсний чийг багтаамж ихтэй.

БУЯНТ ГОЛЫН АЙ САВЫН ХӨРСНИЙ ЯЛЗМАГИЙН АГУУЛАМЖ



Зураг 4. Буянт голын ай савын хөрсний органикийн агууламж

Буянт голын ай савын жижиг цутгал голын сав газрын хөрсний шинж чанар

Буянт голын ай савыг дотор нь Буянт, Буянт-Ховд, Ганцмод, Чигэртэй, Дэлүүн гэсэн 5 жижиг цутгал голын сав газар болгон хуваан үзсэн. Эдгээр ай савууд нь хөрсөн бүрхэвчийн хувьд тодорхой ялгаа бүхий өвөрмөц шинж чанартай байна.

Хүснэгт 3. Буянт голын ай савын жижиг цутгал голуудын сав газрын хөрсний дундаж ерөнхий хими шинж чанар, тогтмол зузаантай үе давхаргаар (0-30см, 0-50 см, 0-100 см)


Жижиг голын сав	pH _{H2O} (1:2.5)			CaCO ₃ , %			Органикийн агууламж, %			Цахилгаан дамжуулалт (EC2.5), dS/m		
	30см	50см	100см	30см	50см	100см	30см	50см	100см	30см	50см	100см
Буянт	7.7	7.7	7.3	1.68	1.69	1.37	2.09	1.64	1.04	0.15	0.14	0.12
Буянт-Ховд	7.3	7.3	7.1	1.37	1.36	1.15	1.71	1.26	0.80	0.09	0.09	0.07
Ганцмод	7.3	7.4	7.3	1.08	1.06	0.92	3.18	2.25	1.36	0.21	0.21	0.16
Чигэртэй	7.3	7.3	6.8	0.08	0.08	0.08	3.74	2.81	1.62	0.12	0.10	0.06
Дэлүүн	7.6	7.6	7.5	0.93	0.98	0.97	2.34	1.81	1.22	0.32	0.30	0.24
Буянт голын нийт ай сав	7.4	7.4	7.2	1.07	1.08	0.96	2.39	1.78	1.12	0.18	0.17	0.14

Буянт голын сав

Ховд хотоос доошхи хэсэг буюу Буянт голын адаг болон Ховд сумын нутгийн хойд хэсэг хамрагдана. Газрын гадаргын хувьд тэгш талархаг газар зонхилно. Буянт голын адаг орчим нэвчилт ихтэй элс хайргархаг Аллювийн хөрстэй, талархаг газраар *Говийн Бор*, *Цайвархүрэн* хөрстэй. Бусад сав газрын хөрсийг бодвол хөрс нь харьцангуй шүлтлэг давсархаг дунаж pH 7.7, карбонатын агууламж хамгийн их дунджаар 1,69-1,68 %, хөрсний ялзмагийн агууламж өндөр биш Буянт голын савын дээд хэсэгтэй харьцуулбал бага 2,09 -1,64 % байна. Дасвжилтын ерөнхий түвшин өндөр (ЕС 0.15-0.14 dS/b) боловч Дэлүүн, Ганцмодны голоос бага байгаа нь элсэрхэг хайрган хөрс их байгаатай холбоотой болно. Хөрсний нэвчилийн үзүүлэлтүүд хамгийн өндөр байгаа нь элсэрхэг, хайрган хөрс давамгайлдаг байдлаас шалтгаалж байна.

Буянт-Ховд голын сав. Ховд хотоос дээш Хөх сэрхийн нуруу болон Халзан бүргэдэй уулсыг оролцуулан Дэлүүн сумаас доош газар нутгийг хамарсан Буянт голын савын хамгийн том талбайг хамарна. Уулын чулуурхаг хөрс болон Хүрэн хөрс хамгийн их талбай эзэлнэ. Хөрсний химийн ерөнхий шинж чанарын хувьд сул шүлтлэг, карбонатын агууламж дунджаар 1,15-1,37 % байгаа нь голын дээд хэсгийн хөрснөөс илүү, чулуурхаг хөрс ихтэй байгаа учраас ялмагийн агууламж нийт ай савын хэмжээнд хамгийн бага буюу дунджаар 1,26-1,71 %, хөрсний давсжилт хамгийн бага байна. Хөрсний чийгийн багтаамж сав газрын хэмжээнд хамгийн бага байгаа нь чулуурхаг хөрс их байгаатай холбоотой.

БУЯНТ ГОЛЫН АЙ САВЫН ХӨРСНИЙ НЭВЧИЛТ



Зураг 5. Буйнт голын ай савын хөрсний нэвчилт

Хүснэгт 4. Буянт голын ай савын жижиг цутгал голуудын сав газрын хөрсний дундаж ерөнхий ус-физик шинж чанар, тогтмол зузаантай үе давхаргаар (0-30см, 0-50 см, 0-100 см)

Жижиг голын сав	Анхдагч нэвчилт, мм/цаг	Ханасан чийгийн нэвчилт, мм/цаг			Ургамал гундах чийг, мм			Хээрийн чийг багтаамж, мм		
		0-30	0-50	0-100	0-30	0-50	0-100	0-30	0-50	0-100
Буянт	216.1	20.5	24.3	19.6	21.9	35.3	56.6	52.0	85.9	142.6
Буянт-Ховд	111.0	13.2	10.5	8.1	16.6	25.9	44.3	38.1	59.8	104.7
Ганцмод	204.7	21.1	16.8	13.5	26.4	35.6	53.2	60.0	81.5	125.4
Чигэртэй	95.1	12.2	10.6	7.7	21.0	29.9	39.0	49.2	69.4	92.3
Дэлүүн	131.1	16.5	14.3	12.7	22.0	33.8	57.7	50.6	78.6	140.5
Буянт голын нийт ай сав	138.2	15.9	13.7	11.1	20.6	30.8	49.7	47.4	71.7	119.4

Ганцмодны голын сав. Мөнх цас цэвдэг ихтэй өндөр уулархаг газар зонхилно. Органикийн агууламж нилээд өндөр дунджаар 2,25- 3,18 % орчим. Хөрс нь органикийн агууламж өндөр учраас хөрсний хээрийн чийг багтаамж, ургамал гундах чийгийн үзүүлэлтүүд энэ голын савд харьцангуй их байна. Ганц модны голын савын эх орчмоор цэвдэгтэй хөрс нилээд их талбай эзэлнэ. Голын савын доод хэсгээр элс хайргархаг сэвсгэр сийрэг эртний мөсдлөгийн морены хурдас их байгаа учраас нэчилт өндөртэй.

Чигэртэй голын сав. Буянт голын ай савын хамгийн их органикийн агууламж өндөр (3.74-2.81%) хөрстэй газар болно. Карбонатын агууламж мөн хамгийн бага байна. Хөрсний ус чийгийн үзүүлэлтүүд Буянт голын савын дундажтай ойролцоо харин нэвчилт багавтар байна. Нийт сав газрын хэмжээнд хөрсний нэвчилт харилцан адилгүй ялгаатай. Сав газрын эхэн орчимд хөрс нь цэвдэгтэй хад чулуурхаг учраас нэчилт бага байхад адаг хэсгээр сэвсгэр сийрэг эртний мөсдлөгийн морены хурдас ихтэй учраас нэвчилт их байна. Ийм учраас голын урсацын ихэнх хэсэг голын адаг орчимд хөрсөнд нэвчиж багасна.

Дэлүүн голын сав. Буянт голын савын эх орчмын цэвдэгт хөрс багатай голын сав болно. Мөн Дэлүүн сумын хойд хэсэгт байдаг томоохон намгархаг нуга энэ хэсэгт байна. Хөрс нь сул шүлтлэг, органикийн агууламж Чигэртэй, Ганцмодны голоос бага харин давсжилт бусад хамгийн өндөр (ЕС 0.30-0.32 dS/m). Дэлүүний дээд хэсгийн томоохон намгархаг- нуга хөрсний чийгийн багтаамж өндөртэй.

ДҮГНЭЛТ

Буянт голын ай сав нь хэрчигдэл ихтэй уулархаг газар нутаг зонхилсноос шалтгаалж хөрсөн бүрхэвч нь маш их алаг цоог, хөрсний шинж чанар нь ихээхэн ялгаатай байна. Буянт голын ай сав газарт байгалийн бүс бүслүүр, газрын гадаргаас хамааран 3 бүлэг хөрсийг ангилж болно: Уулын чулуурхаг хөрс, Уулс хоорондын хөндий болон талархаг газрын хээрийн хөрс, Голын татам, эрэг орчмын чийгт гарлын хөрснүүд.

Сав газрын эхэн орчимд хөрс нь цэвдэгтэй хад чулуурхаг учраас нэвчилт бага байхад Чигэртэй, Ганц модны адаг хэсгээр сэвсгэр сийрэг эртний мөсдлөгийн морены хурдас ихтэй учраас нэвчилт их байна. Ийм учраас голын урсацын ихэнх хэсэг цутгал голуудын адаг орчимд хөрсөнд нэвчиж байна. Буянт голын савын дунд хэсгээр налуу ихтэй хад чулуурхаг өндөр уултай учраас хөрс нь чулуурхаг, нэвчилт багатай байна. Буянт голын ай савын доод хэсгээр уулын бэл, хажуугийн доод хэсгээр элсэрхэг болон элсэн хучаастай хөрс нилээд их талбайд тархана.

Буянт голын адаг орчимд Аллювийн хөрс нь элсэнцэр хайргархаг учраас нэвчилт ихтэй үржил шимийн ерөнхий түвшин бага байна. Буянтын усалгаатай тариалангийн талбайн хөрс нь үржил шимийн хувьд ихээхэн ядмаг байнгын органик бордоо, бууц хэрэглэж байна. Иймээс ихээхэн хэмжээний усалгаатай тариалангийн талбайг ашиглах тохиолдолд усны хэрэглээнээс гадна хөрсний үржил шимийн асуудал хүндрэлтэй болох эрсдэл байна. Нэгэнт элс хайрга болсон хөрсөнд хичнээн их ус хэрэглээд ургац авах боломжгүй.

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. Андреев С И, “Почвы дельты реки Буянту и Ковдоское аймачное хозяйство”, *Труды Монгольской комиссии №16*. Изд-во Академии наук. Л.,М., 1935
2. Батхишиг О, *Боомын ам-Ховд-Хашаатын хөтөл-Өлгий чийглэлийн автозамын дагуух хөрсний судалгааны тайлан*. Улаанбаатар 2009.
3. Беспалов Н Д, “Монгол орны хөрс”, 1951
4. Доржготов Д, “Монгол орны хөрс” Улаанбаатар 2003.
5. “Guidelines for soil description”. Fourth edition. Food and Agriculture Organization of the United Nations. Prepared by R.Jahn, H.P.Blume , V.B.Asio, O.Spaargaren, P.Schad Rome, 2006.
6. Лхагвасүрэн Ч, “Хар-ус нуур орчмын хөрсний микро элементийг тодорхойлсон зарим дүн”. Газарзүйн ухаанаар боловсролын докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. УБ 2001.
7. “Монгол орны хөрсөн бүрхэвч” Под ред. Ногина Н А, Москва, 1984
8. Монгол орны хөрс ашиглалтын зураг. Масштаб 1 : 1 000 000. ГУГК. 1981 он
9. Мөнхбат Т, Сүрэн Ч. “Ховд аймгийн хөрсний судалгааны тайлан”. Газар зохион байгуулах институт. УБ 1977. Ховд аймгийн хөрсний зураг 1 : 200 000М